

## ОЛОН УЛСЫН МУЗЕЙН ТУРШЛАГААС

**ОХУ-ын Бүгд Найрамдах Татарстан улсын Үндэсний музей хичээлийн шинэ жилийн нээлттэй холбогдуулан өөрийн музейн сургалт хүмүүжлийн хөтөлбөрийн хүрээнд доорх хуваарийг гаргажээ.**

*“Нэгдүгээр ангийнхан” сэдэвт сайн санааны үйлс энэ оны 9 дүгээр сарын нэгнээс Татарстан улсын Үндэсний музейд явагдаж эхэллээ. Сургуулийнхаа алтан босгыг анх давж буй тус улсын бүхий л багачууд 9 дүгээр сарын турш музейдээ үнэ төлбөргүй зочилно. Үүнээс гадна тус музейн ажилтны хүүхдийг анхлан сургуульд элсэн ороход хичээлийн хэрэглэлийг байгууллагаас нь бэлтгэж өгдөг дадал болоод уджээ. Бүгд Найрамдах Татарстан улсын Үндэсний музейгээс зохион байгуулдаг баярын арга хэмжээ нь хүүхэд багачуудын өргөн оролцоо, хөгжил баяраар дүүрэн сэтгэлийн хөдөлгөөн дунд өрнөж хэвшсэн байна. Арга хэмжээ бүхэн хүүхдийн хүмүүжил, сурч мэдэх эрмэлзэл төрүүлэх, сайн үйлс бүтээх, чөлөөт харилцаа зэрэгт чиглэсэн байдаг.*

**10:00, 11:30, 13:00 цагт** /3-7 дугаар ангийн сурагчдад зориулан/ - “Эрдэнэсийн эрэлд” музейн тоглоом. “Эрдэнэс хайгчид” хоёр багт хуваагдаж, зөв замаа сонгох ёстой. Асуултанд зөв хариулсан оролцогч эрдэнэстээ ойртох болно. Эрдэнэсээ олсон баг Татарстаны Үндэсний музейгээс дурсгалын зүйл хүлээн авч, харин олзгүй хоцорсон баг нь урамшуулал авдаг байна.

**10:00 цагт** /бүх насны хүүхдэд/ - “Модон сийлбэр” сан хөмрөгийн үзүүлэн. Хүүхдүүд 19 дүгээр зууны үеийн янз бүрийн модон эдлэлийг үзэж танилцах: уламжлалт ахуйн хэрэглээний модон сав, модон болон дурсан маахай, орос ардын тоглоом гэх мэт.

**10:00 цагт** /бага ангийн хүүдүүдэд/ -“Хөгжилтэй амьтад” сэдэвт тусгай хичээл. “Байгалийн гайхамшиг” сэдэвт музейн танхимын аялал. Идэвхтэй оролцсон хүүхэд бүрд дурсгалт зүйл, урамшуулал бүхий уралдаан тэмцээн болдог.

**11:00 цагт** /бага ангийн сурагчдад/ -“Галын дэргэд зочлох нь” нэртэй музейн хичээл. Хөгжөөнт тоглоом хэлбэрээр явагдах энэ хичээлийн хугацаанд хүүхдүүд пийшингийн үүссэн түүх болон зарим нэгэн жигнэмэг хийх аргатай танилцах бөгөөд энэхүү хичээл нь хөнгөн зоог барьснаар өндөрлөдөг байна.

**11:00 цагт** /бүх насны хүүхдэд/ - “Номын талаар өгүүлэх нь ” сэдэвт сан хөмрөгийн үзүүлэн. Хүүхдүүд музейн сан хөмрөг дөх хамгийн эртний үнэтэй ховор номын цуглуулга болон анхны ном үүсч бий болсон түүх, гарал үүсэл, онцлог зэрэгтэй танилцана..

**11:00 цагт** /бага болон дунд ангийн сурагчдад/ - “Казаны домгууд” сэдэвт чөлөөт ярилцлага., “Казань” гэх нэрийн үүсэл гарлын тухай эртний домог, Кабан нуурын нууцаас, мөн Зилант лууг яагаад сүлдэндээ дүрслэх болсон тухай зэрэг сонирхолтой мэдлэг мэдээллийг олж авдаг байна.

**11.00 цагт** (дунд болон ахлах ангийн сурагчдад) – Татар хэлээр «Уран дарханы ур хийц» сэдэвт хичээл лекц. Музейн цуглуулгад тулгуурлан XVIII- XIX дүгээр зууны эхэн үеийн татар үндэсний гоёл чимэглэлийн зүйлсийн ур хийц, хэв маягийн талаар яриа хийж, музейн сан хөмрөгөөс алт, үнэт эрдэнэсээр хийсэн үзмэр эд өлгийн зургийг үзүүлж, тэдгээрийг урлах арга барилын тухай баримтат кино гаргадаг байна.

**11.00 цагт** (дунд болон ахлах ангийн сурагчдад) –«Шударга ариун амьдрахын тулд ... Л.Н. Толстой ба Толстойнхон Казанид» сэдэвт лекц. Алдарт Толстойн гэр бүлийнхэн хийгээд тэдний Казаний амьдралд оруулсан хувь нэмрийг үзүүлэхийн зэрэгцээ ирээдүйн аугаа их зохиолчийн зохиол бичиж эхлэх болсон үеийн амьдрал, үзэл бодолтой танилцуулдаг. XIX зууны 40-өөд оны үеийн Казань хотын амьдрал, түүх соёл, барилга байгууламж, дүр төрх зэрэгт тулгуурлан Толстойн их сургуульд сурч байсан үе буюу амьдралынх нь 6 жилийн түүхийг нээн үзүүлдэг байна.

**12.00 цагт** (ахлах ангийн сурагчдад) –«Гавъяа байгуулах мөч амьдралд үргэлж байдаг» (XX зууны баатрууд) сэдэвт лекц. Энх цагийн “халуун цэгт” гавъяа байгуулагч эх орон нэгт ах дүүсийн гавъяа зүтгэлээс ишлэн ярилцаж, зурагт хуудас гэрэл зургийн цомог зэргийг үзүүлдэг.

**12.00 цагт** (дунд болон ахлах ангийн сурагчдад)-«Ардын дуу». Ардын дууны үүсч хөгжсөн түүх, домогоос сурагчдад танилцуулж, олонд нэртэй уран бүтээлчдийн бүтээлээс үзүүлэн сонирхуулдаг.

**13.00 цагт** (бага ангийн сурагчид) – «Анчдын мэдэхийг хүсдэг зүйл бол... » сэдэвт хичээлээр ан хийх зориулалт бүхий эртний зэр зэвсэг нум сум, хавх болон эртний аварга биет амьтад болох арслан заан, тахир соёот бар, сэлмэн ганц эвэрт бух зэргийн хамтаар танилцуулна. Хүүхдүүд зэрлэг ан амьтдын мөрөөр “ан хийдэг” байна.

**14.00 цагт** (ахлах ангийн хүүхдүүдэд) –«Ризположенскийн эрдэнэс» музейн тоглоом. Тоглоомд оролцогч нь гайхамшигт үзүүллэгээр аялах хугацаандаа тусгай таавар, оньсого тааснаар нэгэн цагт музейн цуглуулагч Р. В. Ризположенскийн зочдын өргөөндөө /өнөөгийн Үндэсний музей/ нуусан эртний зоос, эрдэнэсийг олж авдаг.

**14.30 цагт** (бага ангийн сурагчдад) –«Цайны ёс жаяг» сэдэвт ярилцлага. Сурагчид цайны үүх түүх, орос татарын цайны уламжлалтай танилцаж, олон янзын цайны хэрэгсэл, сав

данхыг үзэж сонирхдог. Тэрчлэн оросын “цай чанагч” буюу самовар, түүнтэй төстэй олон төрлийн эд зүйлсийн талаар сонирхолтой мэдлэг олж авдаг. Энэхүү ярилцлага нь маш сонирхолтой тоглоом хэлбэрээр өрнөдөг байна.

Өөрсдийн музейн үйл ажиллагаа, онцлог, сан хөмрөгт түшиглэн олон төрлийн боловсролын ажил зохиож үзэгч олныг өөртөө татах, хүүхэд багачуудын танин мэдэхүйн хүсэл зоригийг бадраах эрхэм үүрэг зорилгоо хэрэгжүүлэхдээ дээрхээс санаа авах боломжтойг харгалзан ОХУ-ын музейн вэб сайтаас /[www.museum.ru](http://www.museum.ru) / авч Бүгд Найрамдах Татарстан улсын Үндэсний музейн үйл явдлын мэдээнээс орчуулан толилуулав.

**Ашигласан материал:**

[www.museum.ru/N37553](http://www.museum.ru/N37553)

**М. ЦЭРМАА**

МҮМ-н Музей судлаач

Музейн мэдээлэл. МҮМ-н мэргэжил арга зүй, мэдээллийн сэтгүүл. 2009.ХII.№ 02.

Тал. 18.